




БҮГД НАЙРАМДАХ БОТСВАНА УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Тогтоолын төслийн үндэслэл

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3 дугаар бүлэгт “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14-т Монгол Улс улс төрийн гадаад харилцааны бодлого хэрэгжүүлэхдээ “Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь НҮБ-ын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах, хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ НҮБ, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах” чиглэл баримтлахаар заасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтад заасны дагуу “Улсын Их Хурал нь Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах онцгой бүрэн эрхтэй” тул “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

1.2. Практик шаардлага

Монгол Улсын Ерөнхийлөгч НҮБ-ын гишүүн, манай улстай дипломат харилцаагүй улс орнуудтай дипломат харилцаа тогтоох ажлыг хэрэгжүүлэх санал

тавьсныг Монгол Улсын Засгийн газар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд үндэслэн хэрэгжүүлэх чиглэлээр ажилласан.

НҮБ-ын гишүүн, манай улстай дипломат харилцаагүй улс орнуудтай дипломат харилцаа тогтоох уг саналыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, дипломат харилцаа тогтоогоогүй байсан улс орнуудтай дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурах зөвшөөрөл олгосон. Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурсны дараа дипломат харилцаа тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслийг гарын үсэг зурсан дарааллаар нь улс тус бүрээр боловсруулж, УИХ-д багцлан өргөн мэдүүлэхийг даалгасан.

Үүний дагуу Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох сонирхолтой байгаагаа илэрхийлж, дипломат харилцаа тогтоох тухай Хамтарсан албан мэдээнд 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр гарын үсэг зурсан.

Тус улстай дипломат харилцаа тогтоосноор НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд нийтлэг ашиг сонирхлын төлөө харилцан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах боломж нэмэгдэх ач холбогдолтой юм.

Хоёр. Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулна. Уг тогтоолын төсөл нэг зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоохоор тусгана.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоосноор хоёр талын харилцааг хөгжүүлж, хоёр талын болон олон талт тогтолцооны хүрээнд нийтлэг эрх ашгийн төлөө харилцан дэмжлэг үзүүлж, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн худалдааны байгууллага зэрэг олон талт тогтолцоо, механизмын хүрээнд хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Энэ тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг бодлогын суурь баримт бичигтэй зарчмын хувьд нийцнэ гэж үзэж байна. Тогтоолын төсөлтэй уялдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулийн төсөл боловсруулах, хүчингүй болгох шаардлагагүй болно.